

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/168/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: [gereltekhburtgelaudit02@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit02@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага.....	15
4.3 Зөвлөмж .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/161  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.БУЯНЖАРГАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он / ALBAN BICHIG 19000510

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,157,515.65</b>	<b>23,938,378.65</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,157,515.65</b>	<b>23,938,378.65</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>11,452,715.23</b>	<b>11,542,715.23</b>
35110	Тусгай зориулалттай материал	11,452,715.23	11,542,715.23
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>12,704,800.42</b>	<b>12,395,663.42</b>
35410	Бичиг хэргийн материал	772,700.00	772,700.00
35420	Аж ахуйн материал	9,951,004.42	9,932,004.42
35450	Барилгын засварын материал	228,000.00	228,000.00
35460	Хүнсний материал	1,753,096.00	1,462,959.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>209,156,148.60</b>	<b>252,785,231.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>209,156,148.60</b>	<b>252,785,231.76</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>203,784,148.60</b>	<b>247,413,231.76</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	191,818,040.00	244,282,205.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,375,357.36)	(18,563,036.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,988,150.00	18,788,150.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,651,600.00)	(4,279,429.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,953,816.00	7,953,816.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(194,100.04)	(1,650,523.36)
39217	Ном	245,200.00	882,050.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,372,000.00</b>	<b>5,372,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	5,372,000.00	5,372,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>233,313,664.25</b>	<b>276,723,610.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>500.00</b>	<b>324,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>500.00</b>	<b>324,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>500.00</b>	<b>324,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>500.00</b>	<b>324,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	500.00	324,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>233,313,164.25</b>	<b>276,399,610.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>233,313,164.25</b>	<b>276,399,610.41</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	125,616,943.64	125,616,943.64
51101	Өмч: - төрийн	125,616,943.64	125,616,943.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(68,484,794.43)</b>	<b>(25,398,348.27)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(68,484,794.43)	(68,484,794.43)
51220	Тайлант үеийн үр дүн		43,086,446.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,181,015.04	176,181,015.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>233,313,664.25</b>	<b>276,723,610.41</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>220,233,300.00</b>	<b>256,706,615.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,499,000.00</b>	<b>52,685,815.00</b>

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,499,000.00</b>	<b>52,685,815.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	52,685,815.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	3,499,000.00	52,685,815.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>17,147,400.00</b>	<b>23,581,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	199,586,900.00	180,439,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>5,630,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,630,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>17,147,400.00</b>	<b>17,950,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,147,400.00	17,950,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>221,389,556.72</b>	<b>213,620,168.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>221,389,556.72</b>	<b>213,620,168.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>176,494,592.01</b>	<b>181,694,736.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>122,930,558.17</b>	<b>125,415,918.19</b>
210101	Үндсэн цалин	122,930,558.17	117,668,874.00
210102	Нэмэгдэл	-	2,267,516.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	688,000.00
210104	Урамшуулал	-	4,791,527.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,517,071.12</b>	<b>17,012,309.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,572,997.12	11,851,030.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,237,707.00	1,317,226.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	990,163.00	1,026,902.72
210204	Ажилгүйдлийн даатгал	240,792.00	249,895.30
210205	Эрүүл мэндийн даатгал	2,475,412.00	2,567,253.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,011,979.00</b>	<b>13,250,444.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	979,369.00	1,068,134.00
210302	Түлш, халаалт	12,032,610.00	12,032,310.00
210303	Цэвэр, бохир ус		150,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,497,010.00</b>	<b>2,562,250.00</b>
210401	Бичиг хэрэг	317,000.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	199,900.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	304,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,930,110.00	1,757,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,910,268.00</b>	<b>11,595,533.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,400.00	118,600.00
210502	Хоол, хүнс	12,438,868.00	9,989,633.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	433,000.00	1,487,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар		500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>42,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>352,000.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	352,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,233,705.72</b>	<b>11,358,281.84</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,527.00	624,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	461,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,572,178.72	10,271,931.84

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,894,964.71</b>	<b>31,925,432.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>5,630,900.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	5,630,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	44,894,964.71	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,894,964.71	26,294,532.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,156,256.72)</b>	<b>43,086,446.16</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,156,256.72)</b>	<b>43,086,446.16</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	(68,484,794.43)	233,313,164.25
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	(68,484,794.43)	233,313,164.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	(68,484,794.43)	233,313,164.25
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	43,086,446.16	43,086,446.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	(25,398,348.27)	276,399,610.41

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>216,734,300.00</b>	<b>204,020,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>216,734,300.00</b>	<b>204,020,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	199,586,900.00	180,439,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>5,630,900.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,630,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>17,147,400.00</b>	<b>17,950,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,147,400.00	17,950,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>216,734,300.00</b>	<b>204,020,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>216,734,300.00</b>	<b>204,020,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>171,839,335.29</b>	<b>172,095,367.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>122,930,558.17</b>	<b>125,415,918.19</b>
210101	Үндсэн цалин	92,170,575.15	92,709,517.37
210102	Нэмэгдэл	18,057,924.17	15,832,330.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,352,000.00	4,486,000.00
210104	Урамшуулал	11,350,058.85	12,388,070.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,517,071.12</b>	<b>17,012,309.15</b>

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	14,153,416.53	11,859,431.23
210202	Тэтгэмжийн даатгал	341,367.94	1,308,826.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	273,094.40	1,026,901.25
210204	Ажилгүйдлийн даатгал	66,456.39	249,897.16
210205	Эрүүл мэндийн даатгал	682,735.86	2,567,252.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,011,979.00</b>	<b>13,250,444.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	979,369.00	1,068,134.00
210302	Түлш, халаалт	12,032,610.00	12,032,310.00
210303	Цэвэр, бохир ус		150,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,570,300.00</b>	<b>3,021,050.00</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	199,900.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	50,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	36,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		304,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,170,400.00	2,179,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,092,900.00</b>	<b>11,243,296.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,400.00	45,000.00
210502	Хоол, хүнс	13,559,500.00	9,699,496.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,000.00	1,498,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>42,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>720,000.00</b>	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,454,527.00</b>	<b>1,652,350.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,904,527.00	1,100,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	551,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,894,964.71</b>	<b>31,925,432.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>5,630,900.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	5,630,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>44,894,964.71</b>	<b>26,294,532.66</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,894,964.71	26,294,532.66
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	≡	≡
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	207,009,900.00	172,095,367.34	34,914,532.66	83.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,009,900.00	172,095,367.34	34,914,532.66	83.13

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>207,009,900.00</b>	<b>172,095,367.34</b>	<b>34,914,532.66</b>	<b>83.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>137,696,800.00</b>	<b>125,415,918.19</b>	<b>12,280,881.81</b>	<b>91.08</b>
210101	Үндсэн цалин	89,097,500.00	92,709,517.37	(3,612,017.37)	104.05
210102	Нэмэгдэл	28,905,000.00	15,832,330.69	13,072,669.31	54.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,840,000.00	4,486,000.00	354,000.00	92.69
210104	Урамшуулал	14,854,300.00	12,388,070.13	2,466,229.87	<b>83.40</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,590,000.00</b>	<b>17,012,309.15</b>	<b>1,577,690.85</b>	<b>91.51</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,081,300.00	11,859,431.23	1,221,868.77	90.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,377,000.00	1,308,826.55	68,173.45	95.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,101,600.00	1,026,901.25	74,698.75	93.22
210204	Ажилгүйдлийн даатгал	276,300.00	249,897.16	26,402.84	90.44
210205	Эрүүл мэндийн даатгал	2,753,800.00	2,567,252.96	186,547.04	93.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,450,100.00</b>	<b>13,250,444.00</b>	<b>4,199,656.00</b>	<b>75.93</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,415,200.00	1,068,134.00	3,347,066.00	24.19
210302	Түлш, халаалт	12,834,900.00	12,032,310.00	802,590.00	93.75
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	150,000.00	50,000.00	75.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,040,000.00</b>	<b>3,021,050.00</b>	<b>18,950.00</b>	<b>99.38</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	250,000.00	(150,000.00)	250.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	50,000.00	150,000.00	25.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	36,850.00	13,150.00	73.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	304,500.00	(4,500.00)	101.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,179,700.00	10,300.00	99.53
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>27,868,000.00</b>	<b>11,243,296.00</b>	<b>16,624,704.00</b>	<b>40.34</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	45,000.00	-	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	26,323,000.00	9,699,496.00	<b>16,623,504.00</b>	<b>36.85</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,498,800.00	<b>1,200.00</b>	<b>99.92</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	-	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	-	<b>100,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	100,000.00		100,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,765,000.00</b>	<b>1,652,350.00</b>	<b>112,650.00</b>	93.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,110,000.00	1,100,650.00	9,350.00	99.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	655,000.00	551,700.00	103,300.00	84.23
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>207,009,900.00</b>	<b>198,389,900.00</b>	<b>8,620,000.00</b>	95.84

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>189,059,800.00</b>	<b>180,439,800.00</b>	<b>8,620,000.00</b>	<b>95.44</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	189,059,800.00	180,439,800.00	<b>8,620,000.00</b>	<b>95.44</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>17,950,100.00</b>	<b>17,950,100.00</b>	-	<b>100.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	17,950,100.00	17,950,100.00	-	<b>100.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,630,900.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,630,900.00</b>	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,630,900.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,630,900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,630,900.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,630,900.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,630,900.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,630,900.00	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох
- Хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох
- Хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах
- Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 4,427.8 мянган төгрөгөөр

тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,320.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 4,269.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 3,202.1 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 158.3 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	24,157.5	23,938.4	(219.1)
Үндсэн хөрөнгө	209,156.1	252,785.2	43,629.1
Нийт хөрөнгө	<b>233,313.6</b>	<b>276,723.6</b>	<b>43,410.0</b>
Өр төлбөр	0.5	324.0	323.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>233,313.1</b>	<b>276,399.6</b>	<b>43,086.5</b>
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>233,313.6</b>	<b>276,723.6</b>	<b>43,410.0</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 23,938.4 мянган төгрөг болж, 219.1 мянган буурсан байна.

Бараа материалын дансанд Боловсрол, соёл урлагийн газраас хандиваар ирсэн 73.6 мянган төгрөгийн автомакс, ариутгагч бодис, үнэ төлбөргүй хүлээн авсан 148.1 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 252,785.2 мянган төгрөг болж, 43,629.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 52,464.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 324.0 мянган төгрөг болж, 323.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төв аймаг дахь Төрийн аудитын газарт өгөх аудитын үйлчилгээний хөлс болох 323.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 36,473.3 мянган төгрөгөөр өссөн, үйл ажиллагааны зардлын дүн 7,769.4 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 214,319.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 214,319.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,309.2 мянган төгрөгөөр бууруулж, 207,009.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 207,009.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 189,059.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 17,950.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 180,439.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 17,950.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 198,389.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 172,095.4 мянган төгрөгийг зарцуулж, 26,294.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 5,630.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарт олгох тэтгэмжид зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 252,785.2 мянган төгрөг болж, 43,629.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 52,464.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 158,787.4 мянган төгрөгийн 23 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 146,480.6 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад хөрөнгө бэлтгээгүй, тэмдэглэлт ой арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данс, и баримттай холбоотой 2 зөвлөмжийг, хүүхдийн хоолны үлдэгдэлтэй холбоотой 1 актыг тус тус 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,753.1	1	1,753.1	-	-	100.0
Зөвлөмж	2	-	2	-	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,753.1</b>	<b>3</b>	<b>1,753.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 148,693.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,462.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 426.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 146,804.1 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

#### 4.1 Төлбөрийн акт

1. *Байгууллага нь хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 1,462.9 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", УСНББОУС 12 бараа материалд тавигдах шаардлага, санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

#### 4.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 3 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 426.4 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.8-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Өр төлбөр данстай холбоотой асуудал**

###### 1.1. Илрүүлэлт:

Байгууллага нь 1 байгууллагад өгөх 323.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөрийг үүсгэхгүй ажиллах, холбогдох хууль журмын дагуу төлж барагдуулах

**2. *Шилэн данстай холбоотой асуудал***

**2.1. Илрүүлэлт:**

Төв аймгийн Өндөрширээт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 158,787.4 мянган төгрөгийн 23 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 146,480.6 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Тайлант оны эцэст өр төлбөрийн үлдэгдэлтэй байна	1	323.5							1	323.5
2	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	426.4					1	426.4		
3	Хүнсний материал нөөцөлсөн	1	1,462.9			1	1,462.9				
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>2,212.8</b>	-	-	1	1,462.9	1	426.4	1	323.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	146,480.6							1	146,480.6
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>146,480.6</b>	-	-	-	-	-	-	<b>1</b>	<b>146,480.6</b>
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>148,693.4</b>	-	-	1	1,462.9	1	426.4	<b>2</b>	<b>146,804.1</b>